



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН
ТОГТООЛ

2022 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын
тархалтын "Шар түвшин"-д шилжүүлэх тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27¹ дүгээр зүйлийн 27^{1.1}, 27^{1.4} дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 66 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын 2022 оны 02 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор улсын хэмжээнд гамшгаас хамгаалах "Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг"-ийг цуцалсантай холбогдуулан Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалтын "Шар түвшин"-д 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн шилжүүлсүгэй.

2. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын эсрэг хариу арга хэмжээ, тандалт, эмнэлгийн тусламж үйлчилгээнд тасалдал, доголдол үүсэх хариуцлага, хяналт сулрах зэрэг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүх шатанд авч хэрэгжүүлэхийг Эрүүл мэндийн сайд С.Энхболд болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улсын онцгой комиссын нарийн бичгийн дарга, дэд хурандаа Т.Баярхүү, Улсын онцгой комиссын Шуурхай штабын дарга, бригадын генерал Б.Ууганбаяр нарт үүрэг болгосугай.

ДАРГА



С.АМАРСАЙХАН